



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/13/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Аудитор Х.Билэгбаяр
Утас: 94009818 Цахим хаяг: BILEGBAYARKH@AUDIT.GOV.MN

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	4
3.4 Материаллаг байдал	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 47

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр төсвийн хөрөнгөөр тавилга хэрэгсэл бэлтгэсэн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчиж худалдан авалт хийсэн, бүтэц орон тоог илүү ажиллуулан цалин олгосон, малыг гэрээний дагуу хүлээлгэн өгөөгүй, татварын тодорхойлолтыг илүү, дутуу тооцоолсон, шилэн дансны цахим сайтад мэдээллийг бүрэн байршуулаагүй, нөхөн олговрын авлагын барагдуулалт хангалтгүй зэрэг нийт 62.9 сая төгрөгийн зөрчил нь: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Эрдэнэт сүрэг эзнээ баясгана-У" хөтөлбөрийн хүрээнд малжуулсан ажлын гэрээ, Шилэн дансны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол,

АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь ~~залилан эсвэл алдаанаас~~ үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	151,187,841.00	151,895,341.00
33	АВЛАГА	3,006,216.00	3,006,216.00
335	Бусад авлага	3,006,216.00	3,006,216.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,006,216.00	3,006,216.00
35	БАРАА МАТЕРИАЛ	148,181,625.00	148,889,125.00
354	Хангамжийн материал	38,100,375.00	38,807,875.00
35410	Бичиг хэргийн материал	274,000.00	227,000.00
35420	Аж ахуйн материал	25,063,875.00	31,488,875.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	250,000.00
35440	Түлш, шатах тослох материал	12,762,500.00	6,792,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	50,000.00
35600	Мал амьтад	110,081,250.00	110,081,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	817,863,609.78	760,201,700.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	817,863,609.78	760,201,700.42
392	Биет хөрөнгө	815,009,759.97	758,029,400.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	994,859,545.82	1,034,859,545.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(350,262,571.83)	(444,751,582.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	138,711,775.00	138,711,775.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(109,675,383.76)	(120,332,070.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	148,530,301.40	165,033,301.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(92,145,652.36)	(115,360,453.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,118,881.30	62,285,663.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,356,730.56)	(26,672,816.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	107,651,174.00	107,651,174.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(37,470,659.04)	(44,444,216.42)
39217	Ном	1,049,080.00	1,049,080.00
393	Биет бус хөрөнгө	2,853,849.81	2,172,299.93
39301	Програм хангамж	4,191,000.00	4,191,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,019,550.19)	(3,701,100.07)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,682,400.00	1,682,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	969,051,450.78	912,097,041.42
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	969,051,450.78	912,097,041.42
51	Засгийн газрын хувь оролцоо	969,051,450.78	912,097,041.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		306,473,131.83	306,473,131.83
51101	Өмч: - төрийн	306,473,131.83	306,473,131.83
512	Хуримтлагдсан үр дүн	548,919,639.05	491,965,229.69
51210	Өмнөх үеийн үр дүн	548,919,639.05	548,919,639.05
51220	Тайлант үеийн үр дүн	-	(56,954,409.36)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	113,658,679.90	113,658,679.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	969,051,450.78	912,097,041.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	372,510,152.00	459,511,380.00
12.00	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,435,461.00	55,276,000.00
120.00	Нийтлэг татварын бус орлого	12,435,461.00	55,276,000.00
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,435,461.00	55,276,000.00
1,200,042.00	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,132,000.00	120,000.00
1,200,045.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,303,461.00	55,156,000.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	360,074,691.00	404,235,380.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,002,691.00	10,575,480.00
131,101.00	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	4,000,000.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,002,691.00	6,575,480.00
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	349,072,000.00	393,659,900.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	349,072,000.00	393,659,900.00
2.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	488,430,653.88	516,465,789.36
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	458,430,653.88	516,465,789.36
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	444,507,138.93	484,907,857.36
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,592,254.00	213,518,729.00
210,101.00	Үндсэн цалин	148,470,800.00	155,208,978.00
210,102.00	Нэмэгдэл	31,929,198.00	30,430,266.00
210,105.00	Гэрээт ажлын хөлс	27,192,256.00	27,879,485.00
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,291,138.51	28,546,063.00
210,201.00	Тэтгэврийн даатгал	22,440,738.51	19,594,900.00
210,202.00	Тэтгэмжийн даатгал	400,000.00	2,239,500.00
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	500,000.00	1,791,600.00
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	800,000.00	447,900.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	2,150,400.00	4,472,163.00
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,864,882.54	21,315,290.00
210,301.00	Гэрэл, цахилгаан	1,973,382.54	1,104,790.00
210,302.00	Түлш, халаалт	9,891,500.00	20,210,500.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	25,675,098.00	20,803,180.00
210,401.00	Бичиг хэрэг	2,824,500.00	2,512,390.00
210,402.00	Тээвэр, шатахуун	13,552,330.00	15,873,540.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695,100.00	695,200.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	775,500.00	1,722,050.00
2,105.00	Нормативт зардал	1,270,350.00	720,600.00
210,502.00	Хоол, хүнс	416,850.00	426,600.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	853,500.00	294,000.00

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,073,000.00
210,604.00	Урсгал засвар	-	9,073,000.00
2,107.00	Томилолт, зочны зардал	2,640,000.00	42,000.00
210,702.00	Дотоод албан томилолт	2,640,000.00	42,000.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,113,901.00	4,972,556.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,961,071.00	3,491,106.00
210,803.00	Даатгалын үйлчилгээ	414,450.00	369,450.00
210,805.00	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,500.00	340,000.00
210,807.00	Газрын төлбөр	127,192.00	750,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	159,059,514.88	185,916,439.36
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	40,064,280.00	45,584,748.00
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,995,234.88	140,331,691.36
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,923,514.95	31,557,932.00
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	496,000.00	2,933,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	496,000.00	2,933,000.00
2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,427,514.95	27,862,058.00
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,419,514.95	27,862,058.00
2,135.00	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,000.00	762,874.00
213,503.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,000.00	762,874.00
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(115,920,501.88)	(56,954,409.36)
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(115,920,501.88)	(56,954,409.36)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	548,919,639.05	969,051,450.78
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	548,919,639.05	969,051,450.78
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-56,954,409.36	-56,954,409.36
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	491,965,229.69	912,097,041.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	367,146,691.00	404,355,380.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,132,000.00	120,000.00

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	1,132,000.00	120,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,132,000.00	120,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,132,000.00	120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366,014,691.00	404,235,380.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,942,691.00	10,575,480.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,942,691.00	6,575,480.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	349,072,000.00	393,659,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	349,072,000.00	393,659,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	337,146,691.00	372,735,598.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,146,691.00	372,735,598.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	323,223,176.05	341,177,666.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,592,254.00	213,518,729.00
210101	Үндсэн цалин	148,470,800.00	155,208,978.00
210102	Нэмэгдэл	31,929,198.00	30,430,266.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,192,256.00	27,879,485.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,291,138.51	28,546,063.00
210201	Тэтгэврийн даатгал	22,440,738.51	19,594,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	400,000.00	2,239,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	500,000.00	1,791,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	800,000.00	447,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,150,400.00	4,472,163.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,024,882.54	15,344,790.00
210301	Гэрэл, цахилгаан	1,973,382.54	1,104,790.00
210302	Түлш, халаалт	15,051,500.00	14,240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,902,430.00	20,316,180.00
210401	Бичиг хэрэг	2,703,500.00	2,465,390.00

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	13,552,330.00	15,873,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695,100.00	695,200.00
210404	Ном, хэвлэл	55,000.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,884,500.00	1,232,050.00
2105	Нормативт зардал	1,270,350.00	720,600.00
210502	Хоол, хүнс	416,850.00	426,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	853,500.00	294,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	15,323,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	250,000.00
210602	Тавилга	-	2,500,000.00
210604	Урсгал засвар	-	12,573,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,640,000.00	42,000.00
210702	Дотоод албан томилолт	2,640,000.00	42,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,113,901.00	4,972,556.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,961,071.00	3,491,106.00
210803	Даатгалын үйлчилгээ	414,450.00	369,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,500.00	340,000.00
210807	Газрын төлбөр	127,192.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,388,220.00	42,393,748.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,388,220.00	42,393,748.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,923,514.95	31,557,932.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	496,000.00	2,933,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	496,000.00	2,933,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	496,000.00	27,862,058.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,419,514.95	27,862,058.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,000.00	762,874.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,000.00	762,874.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,000,000.00	31,619,782.00

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	31,619,782.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	31,619,782.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	31,619,782.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	31,619,782.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(31,619,782.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	394,259,900.00	365,917,842.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,259,900.00	365,917,842.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,259,900.00	362,984,842.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,945,700.00	213,518,729.00
210101	Үндсэн цалин	156,065,200.00	155,208,978.00
210102	Нэмэгдэл	31,929,200.00	30,430,266.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,951,300.00	27,879,485.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,552,800.00	28,546,063.00
210201	Тэтгэврийн даатгал	19,594,900.00	19,594,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,239,500.00	2,239,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,791,600.00	1,791,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	447,900.00	447,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,478,900.00	4,472,163.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,780,000.00	15,344,790.00
210301	Гэрэл, цахилгаан	7,400,000.00	1,104,790.00
210302	Түлш, халаалт	14,300,000.00	14,240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,811,800.00	17,407,180.00
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,465,390.00
210402	Тээвэр, шатахуун	13,419,000.00	13,024,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,800.00	695,200.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,250,000.00	1,172,050.00
2105	Нормативт зардал	850,000.00	720,600.00
210502	Хоол, хүнс	550,000.00	426,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	294,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,000,000.00	46,942,782.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,000,000.00	16,503,000.00
210602	Тавилга	18,000,000.00	17,866,782.00
210604	Урсгал засвар	13,000,000.00	12,573,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,433,400.00	42,000.00
210702	Дотоод албан томилолт	2,433,400.00	42,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,600,000.00	1,481,450.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	369,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	22,000.00

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	340,000.00
210807	Газрын төлбөр	750,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,286,200.00	38,981,248.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,286,200.00	38,981,248.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	2,933,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	2,933,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,933,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	394,259,900.00	365,917,842.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	394,259,900.00	365,917,842.00
132001	Орон нутгийн төсвөөс	394,259,900.00	365,917,842.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,812,606.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,812,606.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,812,606.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,909,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,849,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,491,106.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,491,106.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,412,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,412,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,812,606.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,812,606.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,812,606.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Билэгбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/49 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газар нь “Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албаны стандартыг хангах, төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлан хэрэгжүүлэх, засаг даргыг цаг үе олсон мэргэжлийн зөвлөмжөөр хангах зорилготой” байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зарлага 303.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын нийт зардал 516.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.3 сая төгрөг, 80 хувь буюу 8.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6 хувиар буюу 56.9 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 148.9 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар ирсэн бараа материалтай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 51.2 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 4.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 54.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 148.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,515.6 сая төгрөг болж 82.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 31.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 51.1 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант оны эцэст 1,515.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 969.0 сая төгрөг болж 56.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 492.0 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 314.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 394.3 төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс 79.5 сая төгрөгөөр өссөн нь тээвэр шатахуун, урсгал засвар, засаг даргын нөөц хөрөнгийн зардлуудад тодотгол хийсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 394.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 394.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 365.9 сая төгрөгийг зарцуулж 28.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 365.9 сая төгрөг буюу 93 хувьтай байгаа нь 28.4 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 10.6 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба 9.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт худалдан авалтын И баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 393.8 сая төгрөгийн 146 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 364.7 сая төгрөгийн 144 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан, 29.1 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 14.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.9.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 1.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 19.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар: Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 68.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.1 сая төгрөгийг залруулан, 64.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланг 4.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

4.3 Албан шаардлага

- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 4.6 сая төгрөгийг баяр ёслол тэмдэглэлт арга хэмжээнд зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6-т "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчиж 14.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер

шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

- Батлагдсан бүтэц, орон тооноос 2 ажилтан илүү ажиллуулан 10.9 сая төгрөгийн цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох";, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолын 1-т "Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- И баримтгүй 1.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байнга нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Татварын тодорхойлолтоор 16.3 сая төгрөгийн 12 нэр төрлийн татварын өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- "Эрдэнэт сүрэг эзнээ баясгана-Ү" хөтөлбөрийн хүрээнд 24 толгой 16.8 сая төгрөгийн малыг гэрээний дагуу дараагийн малчинд хүлээлгэн өгөөгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", "Эрдэнэт сүрэг эзнээ баясгана-Ү" хөтөлбөрийн хүрээнд малжуулсан ажлын гэрээний 2.1-т " Малжуулахаар өгсөн малыг гурван жилийн хугацаанд сайн маллаж, төлөө авч, малаа өсгөөд "Эрдэнэт сүрэг эзнээ баясгана-Ү" хөтөлбөрөөс авсан малаа зүс дугаар, тоогоор нь 2015 оны 10 сарын 01-нд багтаан дараагийн малчинд хүлээлгэн өгнө" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төсвөөс олгосон 3.0 сая төгрөгийн нөхөн олговрын авлагыг одоог болтол барагдуулаагүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн

этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1.-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1, цалингийн зардлаас бусад зарлагын 1 нийт 2 төрлийн мэдээллийг байршуулаагүй байна.

3.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-т Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг мөрдөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тонхил сумын ЗДТГ	9.0	68.2	1	4.1	0.0	0.0	8	64.1	1.0	0.0